



Ambassade van het
Koninkrijk der Nederlanden

ХААХУЯ, БОЛЖИ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra
Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



Mongolia

“Цэлжилтийг бууруулах, газрын тогтвортой менежмент”
МОН08/301/Төсөл

Х.Жалбаа (Ph.D)

ХАЙЛАС

ТАРЬЖ УРГУУЛАХ ГАРЫН АВЛАГА

(2 ДАХЬ УДААГИЙН ХЭВЛЭЛ)

Редактор А.Авиurmэд (Ph.D)

Улаанбаатар. 2010 он

DDC
634.9728'023
Ж-213

Энэхүү товхимолын эрх хамгаалагдсан учир бүтнээр нь буюу хэсэгчлэн хэвлэх, хувилан олшруулахыг зөвхөн зохиогчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

ISBN 978-99929-1-538-2

Гарчиг

Оршил.....	5
Хайласны биологи, ургах орчны нөхцөл.....	7
Хайлас тарих бэлтгэл ажил.....	8
Хайласыг ямар зориулалтаар тарьж болох вэ?.....	8
Тарих суулгацыг сонгох.....	9
Суулгацыг тээвэрлэх, хадгалах.....	9
Суулгац суулгах нүхний хэмжээ.....	10
Суулгацыг нүхэнд суулгах.....	11
Суулгацыг шуудуунд суулгах.....	11
Арчилгаа.....	12
Элсэргэх хөрстэй газар нутгийг ойжуулах.....	12
Таримал хайласыг хамгаалах	15

ОРШИЛ

Хайлас бол байгаль, цаг уурын харилцан адилгүй бүс нутгуудад зохицон ургах биологийн онцлогтой модлог ургамал юм. Иймээс хайласыг хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, ойн зурvas байгуулах, элсэрхэг нутгийг ойжуулах, эрэг гангыг бэхлэх зэрэг ойжуулалтын олон төрөлд ашиглаж болдог ажээ. Тэрчлэн монголчууд эрт дээр үеэс хайласыг “ариун мод” гэж үзэж хурал номын газар, сүм дуганы орчим, тахилгат уул овоо зэрэг ариун дагшин газартаа тарьж байсан тухай сурвалж бичигт тэмдэглэгдэн үлдсэн бөгөөд одоо ч түүний ул мөр бий гэж зарим судлаачид үздэг байна. Эдүгээ ч хайласыг хангай, говь нутагт тарьж туршиж эхэлж байна. Иймээс НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, ХХААХҮЯ, БОАЖЯ-ны хамтран хэрэгжүүлж байгаа “Цөлжилтийг бууруулах, газрын тогтвортой менежмент” төслөөс “Хайлас тарьж ургуулах гарын авлага” товхимолыг бэлтгэж 2 дахь удаагаа нийтийн хүртээл болгож байна. Энэхүү гарын авлагад хайласны биологи, ургах орчны онцлог, суулгацыг зөв сонгох, тээвэрлэх, түр хадгалах, суулгаж тарих, шимт хөрс, бууц бордоо бэлтгэх, найруулах, хэрэглэх, таримал хайласыг арчлах, услах, хамгаалахад зайлшгүй шаардлагатай техникийн үзүүлэлт, агротехнологийн горимыгтовч тодорхой тусгахыг хичээсэн болно. Хайлас тарих гарын авлагын талаарх саналаа “Цөлжилтийг бууруулах, газрын тогтвортой менежмент” төсөл, Энхтайвны гудамж 1ба, Засгийн газрын IX байр, ХХААХҮЯ, 28 тоот, утас: (976)-11463150, факс: (976)-11463032 гэсэн хаягаар ирүүлэхийг хүсье.

Х.Жалбаа

Хайлас-Ulmus.L

Хайласны биологи, ургах орчны нөхцөл

Хайлас нь Монгол орны хангай, говь, хээрийн бүсэд хаана л бол хаана ургадаг томоохон сөөг хэлбэртэй мод юм. Хайлас хавар навч нь дэлгэрэхээс өмнө цэцэглэж үрлэнэ.

Үр нь боловсорч гүйцэх үедээ далавчтит үр жимс нь ногоон өнгөтэй байснаа шар цайвар өнгөтэй болно. Бүрэн гүйцэд боловсорсон үрийн далавчны гол дахь хөврөл хатуурч имрэхэд хурууны өндгөнд мэдрэгддэг болно.



Хайласны үрийг говь цөлийн бүсэд 4-р сарын сүүлч 5-р сарын эхээр, хээрийн бүсэд 5-р сарын дунд ба сүүлчээр түүнэ. Боловсорч гүйцсэн үрийг эх модноос нь шувтарч түүхээс гадна газарт унасныг цуглуулан авч болно. Үрийг түүгээд шууд тарина. Тарьж амжаагүй үрийг хадгалаад дараа жил тарьж болно.

Хайлас нь ганд тэсвэртэй, сайтар усалж арчлахад үндэснээсээ амархан сэргэн ургадаг. Түүнчлэн эгнүүлж тариад жил бүр танаж засаж ногоон хашлага болгоход нэн тохиromжтой.

Хайлас тарих бэлтгэл ажил.

Та хайласыг тарихын тулд дараах бэлтгэлийг хангах шаардлагатай.

- ❖ Хайласны биологи, ургах орчны талаар зохих мэдлэгтэй байх
- ❖ Хайлас ургах газрыг зөв сонгон хашиж хамгаалсан байх
- ❖ Усалгааны усны эх үүсвэрийг шийдэх
- ❖ Өөрт хэрэгцээтэй суулгацыг зөв сонгож авах
- ❖ Сонгосон суулгацаа технологийн дагуу зөв тээвэрлэж, хадгалах
- ❖ Суулгац суулгаж тарих нүхийг ухаж бэлтгэх
- ❖ Суулгац тарих нүхэнд орох хар шороо (шимт хөрс), бууц, элс, бордоог хүрэлцэх хэмжээгээр бэлтгэж бэлэн болгох
- ❖ Ажлын багаж хэрэгслийг бэлтгэх

Хайласыг ямар зориулалтаар тарьж болох вэ?

Манай оронд хайласыг дараах чиглэлээр ойжуулж тарина.

- Элсэрхэг нутгийг ойжуулах
- Ойн зурвас байгуулах
 - Тариалангийн талбайг хамгаалах
 - Зам харгуйг хамгаалах
 - Нөмөр, халх, ногоон бус байгуулах
- Төв суурин газрыг цэцэрлэгжүүлэх
- Хувийн эзэмшлийн хашаанд тарих
- Эрэг ганга бэхлэх зэрэгт тарьж болно.



Тарих суулгацыг сонгох

Та, нүүдэг сүл элсийг тогтвортжуулах зорилгоор элсний хормой, тэдгээрийн хоорондох нам хотосоор тарих бол 1-2 настай суулгацыг сонгож болно. Хэрэв ойн зурvas, төв суурин газрыг цэцэрлэгжүүлэх, хувийн эзэмшлийн хашаанд тарих, өвөлжөө, хаваржааны орчимд ногоон нөмөр халх байгуулах, эрэг гангандын ирмэг хөвөөгөөр тарьж ойжуулах бол 3-4 настай суулгац тохирно. Таны сонгосон суулгацны үндэс нь хэдий чинээ сахлаг, олон салаалсан байвал төдий чинээ сайн ургана.


Суулгацыг тээвэрлэх, хадгалах

- ❖ Суулгацыг тээвэрлэж хадгалахад хамгийн гол анхаарах зүйл бол үндсийг нь хатаахгүй байх явдал юм.
- ❖ 1-2 настай суулгацыг 100-150 ширхэгээр, 3-4 настай суулгацыг 50-70 ширхэгээр нь багцлан боогоод үндсийг нь хар шорооны нойтон зуурмагт дүрж бэхжүүлээд түүнийгээ нийлэг хальсаар 2-3 давхар боож хамгаалж тээвэрлэнэ.
- ❖ Хайлласны суулгацыг тарихын өмнө багцнаас нь задлаад үндсийг нь бүтнээр нь нойтон шороогоор булж түр хадгална.




Суулгац суулгах нүхний хэмжээ

- ❖ Хайласны суулгацыг нүхэнд суулгаж тарина.
- ❖ Элсэнд нэг настай суулгацыг суулгах нүхний голч 20-30 см, гүн 30 см байна.



1 дүгээр зураг. 1настай суулгацыг суулгаж тарих бүдүүвч

- ❖ 2-3 настай суулгацаанд 40-50 см голчтой, 50 см гүн нүх тохирно.
- ❖ 4 настай суулгацыг дээрхээс арай том нүхэнд суулгаж тарина.



2 дугаар зураг. 2-3 настай суулгацыг тарих бүдүүвч

Таримал хайласыг услах горим

№	Усалгааны хугацаа	
1	4 дүгээр сарын 20-ноос 5 дугаар сарын 1	10 хоногт 1удаа
2	5 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 1	7 хоногт 1удаа
3	6 дугаар сарын 15-наас 8 дугаар сарын 15	3-5 хоногт 1удаа
4	8 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 15	10-15 хоногт 1удаа
5	Газар хөлдөхөөс өмнө 2-3 долоо хоногийн өмнө	Цэнэг услагаа

Суулгацыг нүхэнд суулгах

Хайласны суулгацыг суулгах нүхэнд хийх шороог урьдчилан бууц, элстэй хольж бэлтгэнэ. Үүний 50% хар шороо, 30% элс, 20% бууц байна.

Суулгацыг суулгахын өмнө нүхний талд хүртэл шахам хольсон хар шороогоо хийгээд усална. Энэ усыг шингэхээр нүхний голд суулгацыг босгон барьж үндсийг нь жигд тараан байрлуулаад шорооны холимогийг дахин хийж усална.

Хоёр дахь удаагийн усалгааны усыг шингэмэгц дээрээс нь хуурай шороо хийж сайтар гишгэж чигжинэ. Дараа нь суулгацын гол ишнээс дээш татаж хэр зэрэг суусныг шалгаж үзнэ. Татаж үзэхэд суулгасан суулгац сугарахааргүй чигжигдэж, хөдөлгөөнгүй бат бэх болсон байх ёстой.

Суулгацыг шуудуунд суулгах


- ❖ Ногоон хашлага болгох хайласыг шуудуунд суулгаж тарина.
- ❖ Шуудууны өргөн 30 см, гүн нь 40-50 см байна.

- ❖ Хайласны суулгацыг шуудууны хоёр ханыг дагуулан суулгаж тарина.
- ❖ Ногоон хашлага болгох хайласыг хооронд нь 20-25 см зйтай суулгана.
- ❖ Суулгах арга нь нүхэнд суулгаж тарихтай адил байна.

Арчилгаа


- ❖ Таримал хайласны арчилгааны гол ажил усалгаанд чиглэгдэнэ. Нэг модыг услах усны хэмжээ байгаль, цаг уурын нөхцөл, модны наснаас хамаарч өөр өөр байх боловч дунджаар 30-40 л ус орно.
- ❖ Ургамал ургалтын хугацаанд 2-3 удаа тогооны доторх зэрлэг ургамлыг устгаж, хөрсийг сийрүүлнэ.

Элсэрхэг хөрстэй газар нутгийг ойжуулах




3 дугаар зураг. Манхан элсэнд хайлас тарих бүдүүвч

Нүүдэг сул элсийг тогтвортжуулахын тулд манханы хормой, тэдгээрийн хоорондын нам тэгш газраар үрээр шууд тарих буюу эсвэл тарьцыг шилжүүлж тарина.



4 дүгээр зураг. Элсэн хучаастай хөрсөнд хайлас тарих бүдүүвч

Мөн энэ зорилгоор хайлласны үрийг жижиг үүрэнд тарьж болно.



5 дугаар зураг. Хайлласны үр тарих бүдүүвч


Хайлласны үрийг 5 дугаар зурагт үзүүлснээр нэг үүрэнд 20-иод ширхэгийг хийгээд элсээр нимгэн хучиж, гишгэж нягтуулна.

Хайлласны үрийг бороотой үед чийглэг элсэнд тарина.

Гантай үед хуурай элсэнд тарьж болохгүй.

Ойжуулалтанд 1 ба 2-3 настай суулгацыг суулган тарьж болно.


Суулгац суулгах мөр хоорондын зайд 2 м, ургамал хоорондын зайд 1,5-2 м байна.



6 дугаар зураг. Ойн зурвасанд хайллас тарих бүдүүвч

Тариалангийн талбай, зам харгуйг хамгаалах, өвөлжөө хаваржаанд халх нөмөр болгох зорилгоор тарих ойн зурvasанд хайласны 2-3 настай суулгацыг 3-5 эгнээгээр тарина.

Төвсуурин газрын цэцэрлэгжүүлэлт, нийтийн эзэмшлийн парк, гудамж талбай, байгууллага орчны тохижилтонд хайласыг ганц нэгээр нь болон төгөл, баг үүсгэж тарих ба амьд хашлага болгон тарихад нэн тохиромжтой.



7 дугаар зураг.
Өвөлжөө хаваржааны орчимд ногоон халх
байгуулах бүдүүвч

Малчны өвөлжөө хаваржааны салхины дээд талаар нөмөр, халх болгож байгуулах ногоон бүсэнд хайласыг 4 ба түүнээс дээш эгнээгээр бусад төрлийн мод сөөгтэй хольж суулган тарьж болно.

Эрэг гангыг бэхэлж хамгаалахад хайласыг үндсэн төрлийн мод болгож тарьж суулгаж болно.

Таримал хайласыг хамгаалах

Тарьсан модонд өвчин, хортон шавж илэрвэл мэр-гэжлийн байгууллага, хүмүүст хандах нь зүйтэй. Таримал хайласыг аливаа гэмтлээс хамгаалах нөхцлийг бүрдүүлэн хашиж хамгаалах шаардлагатай. Суулгасан суулгацыг мэрэгчид идэж гэмтээх, хугалах зэргээр сүйтгэх тул нарийн төмөр төрөн хашаа барьж хамгаалах хэрэгтэй.





Хайлас тарьж ургуулах гарын авлага

Зохиогч:	Х.Жалбаа (Ph.D)
Редактор:	А.Авиurmэд (Ph.D)
Дизайн, зураг хэвлэлийн	
эхийг бэлтгэсэн:	Б.Сарнай
Хэвлэлийн хуудас	1.0
Хэвлэсэн тоо:	500 ш
Хэвлэсэн огноо:	2010-06-01
Цаасны хэмжээ	60x88/16

“Мөнхийн Үсэг Групп” ХХК-д хэвлэв.